

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОРОН ТООНЫ ЗАР

2023.11.13

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газарт “Монгол Улсын Ерөнхий аудиторов Орлогчийн албан тушаалын орон тоог зарлаж байна.

Нэг “Монгол Улсын Ерөнхий аудиторов Орлогч”

1. Албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага
 - Монгол Улсын иргэн байх;
 - Дээд боловсролтой байх;
 - Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
 - Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
 - Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (эрэгтэй);
 - Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч байх.
 - Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;
2. “Монгол Улсын Ерөнхий аудиторов Орлогчийн Албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Орон тоонд тухайн албан тушаалд тавигдсан боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагч бүртгүүлнэ.

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	-Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/; -Санхүү /041201/; -Эдийн засаг /0311/; -Менежмент ба удирдахуй /041301-041303/; -Математик статистик /054/; -Эрх зүй /042/	
Мэргэшил	-Тэргүүн түшмэл эсхүл түүнтэй адилтгах мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх. - Англи хэлний шалгуур IELTS 7.0 ба түүнээс дээш, TOFEL 550 ба түүнээс дээш оноотой байх, эсхүл өндөр хөгжилтэй оронд дээрх мэргэжлээр мастер болон түүнээс дээш зэрэгт суралцаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс төрийн аудитын зөвлөх түшээ эсхүл төрийн захиргааны эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- байгууллагын стратегид чиглүүлэн ажлын гүйцэтгэлийг удирдах; - эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх; - аудитын нэгж, албан хаагчдын ажлын уялдаа холбоог хангах; - стратегич сэтгэлгээтэй, уян хатан, хөрвөх чадвартай байх; - албан хаагчдын бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжиж, хувь хүний ялгаатай байдал, онцлогийг харгалзан

		удирдах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах;
	Дүн шинжилгээ хийх	- баримт нотолгоо, дүгнэлтийг задлан шинжлэх, шийдвэр гаргах - мэдээлэл, судалгааны дүгнэлтэд тулгуурлан бодлогын санал, зөвлөмж боловсруулах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - чиг үүргийн шинжилгээ хийх чадвартай байх - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжид тусгуулах, тусгах санал боловсруулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргахад удирдлагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх
	Манлайлах	- хувийн зан төлөв, зарчимч, тууштай байдал, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; - байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчийн шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, үлгэрлэн хэрэгжүүлэх; - өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолох; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - багаар ажиллах чадвар эзэмшсэн байх;
	Бусад	- албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөгөө өгөх чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - албан бичиг, захидал боловсруулах, харилцааны соёлыг эзэмшсэн байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - багаар ажиллах чадвар эзэмшсэн байх; - харилцааны оновчтой арга барилаар асуудлыг шийдвэрлэх; - төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах; - үндэсний бичгийн хэлээр уншиж, бичих чадвартай байх.

Хоёр. Шалгалт өгөхийг хүссэн албан хаагч бүртгүүлэхдээ дор дурдсан бичиг баримтыг цахимаар бүрэн ирүүлнэ. Үүнд:

- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (диплом) Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар эсхүл Цахим лавлагаа ("e-mongolia" - аас татан авах);
- "4 х 6"-ийн хэмжээний цээж зураг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт.
- Төрийн албанд ажилласан жил тооцох зорилгоор албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн "Тангаргийн хуудас" -ын хуулбар;
- Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн сүүлийн гурван жилийн үнэлгээ;
- Иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia—аас татан авах) ;
- Сүүлийн 1 жилийн дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүйг нотлох бичиг баримт;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

Албан тушаалын орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцох албан хаагчийн хүсэлт, холбогдох баримт бичгийг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 17:30 цаг хүртэл Үндэсний аудитын газрын 306 тоотод хүлээн авна.

Дөрөв. Хүсэлт ирүүлсэн албан хаагчдад мэдээлэл хүргэх:

Орон тоо нөхөх тусгай шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн албан хаагчийн бичиг баримтыг хянаж, албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэх тухай мэдээлэл болон тусгай шалгалтыг зохион байгуулах хугацааг албан хаагчийн цахим хаягаар мэдэгдэнэ.

Холбоо барих утасны дугаар
Үндэсний аудитын газар: 51-261585

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР